

Шимтгэлийн хэмжээг бууруулахыг  
санал болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр болон үүргийн гүйцэтгэлийг үнэт цаасны барьцаагаар хангахад хийгдэх өмчлөх эрхийн бүртгэлийн шимтгэлийн дээд хэмжээг дараах байдлаар тогтоохыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүхбаатар/-д санал болгосугай.

а/ үнэт цаасны үнийн дүнг шийдвэрт заасан бол тус үнийн дүнгээс, заагаагүй бол шийдвэр гаргасан өдрийн хаалтын ханшийг тухайн гүйлгээгээр шилжүүлж буй үнэт цаасны тоонд үржүүлж тооцсоны 0.2 хувиас ихгүй, гэхдээ уг тооцсон хэмжээ нь 100,000 төгрөгөөс илүүгүй байхаар;

б/үүргийн гүйцэтгэлийг үнэт цаасны барьцаагаар хангахад хийгдэх өмчлөх эрхийн бүртгэлийг хийх өдрийн өмнөх өдрийн ханшийг тухайн гүйлгээгээр шилжүүлж буй үнэт цаасны тоонд үржүүлж тооцсоны 0.2 хувиас ихгүй, гэхдээ уг тооцсон хэмжээ нь 100,000 төгрөгөөс илүүгүй байхаар.

2.Тогтоолын дагуу шимтгэлийн хэмжээг өөрчлөх асуудлыг 2008 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан шийдвэрлэж Хороонд мэдэгдэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүхбаатар/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ